



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах,  
хаягийн өөрчлөлт хийх, хүчингүй болгох тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 10.1.5, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 35.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн 2019 оны 2 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын стандартын шаардлагын биелэлтийг хангаж спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох 10 аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалтыг 1 дүгээр, худалдааны газрын стандартын шаардлагын биелэлтийг хангаж спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг шинээр олгох 8 аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалтыг 2 дугаар, спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 2 аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартын шаардлагын биелэлтийг хангаж спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгах 7 аж ахуйн нэгжийн жагсаалтыг 4 дүгээр, худалдааны газрын стандартын шаардлагыг хангаж спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг сунгах 12 аж ахуйн нэгжийн жагсаалтыг 5 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Хаягийн өөрчлөлт хийсэн спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх 2 аж ахуйн нэгжийн жагсаалтыг 6 дугаар, аж ахуйн нэгжийн хүсэлтээр болон нэр шилжсэний улмаас хүчингүй болгох 3 аж ахуйн нэгжийн жагсаалтыг 7 дугаар, нэр шилжүүлсний улмаас хүчингүй болгох

1110300105